



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар A/08

Улаанбаатар хот

**БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАЖ
АЖИЛЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 19 тоот Албан даалгаврыг үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай Албан даалгаврын хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төв нь 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн бэлэн байдалд шилжиж ажилсугай.

2. Бэлэн байдалд шилжин ажиллах болсонтой холбогдуулан мэргэжлийн багийг нэгдүгээр, нөөц орны тоог хоёрдугаар, нөөц орон дээр ажиллах албан хаагчдыг гуравдугаар, бэлэн байдлын үеэр ажиллах нөөцөд байлгах албан хаагчдыг дөрөвдүгээр, санхүүтэй холбоотой асуудлыг тавдугаар, тээвэрлэх машиныг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 19 тоот Албан даалгаврыг удирдлага болгож, тушаалын хэрэгжилтэд хатуу хяналт тавьж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал /Б.Батцэцэг/-д үүрэг болгосугай.

4. Бэлэн байдлын үеэр зарцуулах хөрөнгө, мөнгийг хавсралтаар баталж, зориулалтын дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /Ш.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ *Ц.Уранчимэг* Ц.УРАНЧИМЭГ



1411900055